



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



JAPAN INTERNATIONAL  
COOPERATION AGENCY

**Улаанбаатар хот дахь ХБИ-ийн  
нийгмийн оролцоог дэмжих  
төсөл (DPUB)**

Мэдээллийн эмхэтгэл №18



**Хөгжлийн бэрхшээлийн тухай цуврал хичээл (2018.07.31)**

7-р сарын 25-ны өдөр СЗСҮТ-д Хөгжлийн бэрхшээлийн тухай 4 дэх удаагийн цуврал хичээл зохион байгуулагдлаа. Энэ удаа “Монгол улс дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бусад улсын жишээ” сэдвээр лекц орсон бөгөөд ойролцоогоор 50 гаруй хүмүүс оролцож, санал бодлоо солилцлоо. Төслийн ахлах зөвлөх Чиба тэгш хамруулах болон тусгай хэрэгцээт боловсрол, мөн бусад хэлбэрийн боловсролын талаар Монгол, Япон, Тайландын жишээн дээр тулгуурлан танилцууллаа. Ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд суралцаж чадахгүй байх тохиолдол олон байдаг бөгөөд дэлхийн олон оронд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэлтгүй бүх л хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэх асуудлыг хүний эрхийн асуудал хэмээн авч үзэн дэмжин ажиллаж байна. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 20 орчим хувь нь л тусгай хэрэгцээт сургуульд суралцаж буй бөгөөд бусад дийлэнх нь жирийн сургуульд суралцаж

байгаагаараа онцлогтой. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын статистик мэдээллийг зөв гаргасан эсэх, мөн жирийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдаж байгаа тохиолдолд шаардлагатай дэмжлэг тусалцаа, боловсролын систем бүрдсэн байгаа юу гэдгийг судалж тогтоох шаардлагатай гэсэн санал ч гарч байлаа. Жич: Энэ удаагийн хичээлийг фэйсбүүкээр шууд дамжуулсан бөгөөд сургалтанд өөрийн биеэр оролцож чадаагүй хүмүүст мэдээлэл хүрч чадсан гэдэгт итгэлтэй байна.



Сургалтын оролцогчид



**JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE  
дарж нэгдээрэй!!**

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **2760** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.



DET Сургалтын ур чадвараа нэмэгдүүлэхийг зорьж буй сургагч багш нар

**DET Сургагч багш нарын давтлага хичээл (2018.07.18)**

7,8-р сард Монголд хамгийн сайхан улирал тохиодог. Олон хүмүүс хөдөө явж, байгалийн сайханд амралтаа өнгөрөөдөг. Наадмын өмнөх өдөр буюу 7-р сарын 10-нд Дуулим, Нэмэхбаяр, Бямбасүрэн нарын 3 сургагч багш төслийн оффист ирж DET давтлага хичээлд оролцлоо. Дохионы хэлний орчуулагчаар Гоомарал ажилласан. Тэд дасгал ажлуудын дүгнэлт, сургалтанд оролцогчдод агуулгыг хэрхэн үр дүнтэй хүргэх талаар дэлгэрэнгүй суралцахын тулд олон асуулт асууж, харилцан ярилцлаа. Оролцогчдын хариултыг жишээ болгон цаад шалтгааныг нь гаргаж ирэх лавшруулах асуулт болон өөр бусад асуудал руу анхаарлыг нь хандуулах асуултыг хэрхэн тавих аргачлал зэргийн талаар хамтдаа давтлаа. 9-р сараас DET сургалт хийх давтамж олон болно. Түүнээс өмнө сайн бэлтгэл хийх нь чухал. Цаашид ч гэсэн цөөн хүний бүрэлдэхүүнтэй давтлага хичээлийг үргэжлүүлэн зохион байгуулахаар төлөвлөж байна.

## НҮБ дэх ажил: Мэдээллийн хүртээмж, түүний ач холбогдол

2001 онд Бангкок интернет кафе маш олноор нээгдсэн. Гэртээ интернетгүй, ухаалаг гар утасгүй хүмүүс интернет кафе д очиж имэйлээ шалгах, цахимаар мэдээлэл авах боломжтой



*Ахлах зөвлөх Чиб*

учраас маш амар байв. Тиймээс гадаадын аялагчид болоод тайланд хүмүүс ч гэсэн өргөнөөр хэрэглэж байсан. Тухайн үед хөгжиж буй орнуудад интернетийн хэрэглээ хурдацтай нэмэгдэж байлаа. Нөгөөтэйгүүр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд интернетийн ашиг тусыг хүртэж чадаж байсан уу гэвэл тийм биш. Тэдэнд олон саад бэрхшээл тулгарч байлаа. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан текстийг дуу авиа руу хөрвүүлдэг софт өндөр үнэтэй учраас худалдаж авах боломжгүйн дээр мэдээллийн хүртээмж гэх ойлголт ч дэлгэрээгүй байсан. Цаашид интернет, компьютерийн хэрэглээ улам ихсэнэ гэдэг нь тодорхой байсан боловч хөгжиж буй орнуудын хувьд ХБИ байтугай жирийн хүмүүсийн хэрэглээ ч бага байсан. Гэхдээ ХБИ-ийн интернетийн хэрэглээ ч гэсэн ирээдүйд нэмэгдэнэ гэдгийг анзаарч харж байсан надад НҮБ-ын ESCAP дахь ажил маань маш сонирхолтой байв. Улмаар мэдээллийн эрин үе ирж буй яг энэ үед л мэдээллийн хүртээмжтэй байдлыг ханган ажиллах шаардлагатай гэсэн чиглэл рүү намайг хөтөлж байв. (Үргэлжлэл бий...)

## Тэтгэврийн тогтолцооны шинэчлэлтээр нийгмийг өөрчлөх нь ! ЖАЙКА-ийн техникийн хамтын ажиллагааны төслүүд хамтран семинар зохион байгууллаа (2018.07.27)

Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төсөл (SINRAI)-ийн ахлах зөвлөх Ямашита “Монгол улсын нийгмийн хамгааллын салбар дахь шинэчлэл эдийн засгийн хөгжилд нөлөөлөх нь” сэдвээр лекц уншсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-уудын төлөөлөл оролцлоо. DPUB төслийн зүгээс хөгжлийн бэрхшээлийн тухай холбогдох сэдвүүдээр сар бүр цуврал хичээл зохион байгуулдаг бөгөөд энэ удаа SINRAI төсөлтэй хамтарч, шинэлэг сэдвээр семинар зохион байгуулсан юм. Хөгжлийн



*Ахлах зөвлөх Ямашита*

бэрхшээлийн салбарт нийгмийн хамгаалал, тэтгэврийн тогтолцоо нь маш чухал. ХБИ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг чадавхжуулсан ч хүний нөөцийг бүрэн дүүрэн ашиглах үндсэн суурь болох нийгмийн хамгаалал, дэмжих тогтолцоо байхгүй бол ТББ-ын үйл ажиллагаа тогтвортой үргэлжлэх боломжгүй. Нөгөөтэйгүүр хөгжингүй орнуудын жишээнээс харахад нийгмийн хамгааллын тогтолцоо бэхжиж, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр ажиллаж буй байгууллагуудад шаардлагатай хөрөнгө санхүүгийн асуудал шийдэгдсэн байдаг. Гэвч хөгжиж буй орнуудын хувьд эдийн засаг хангалттай хөгжөөгүй учраас санхүүгийн чадамж байхгүй гэдэг шалтгаанаар ТББ-ууд руу чиглэсэн дэмжих тогтолцоо хангалтгүй байна. Гэхдээ Ямашита ахлах зөвлөхийн лекцээс эдийн засаг хангалттай



*Семинарын үеэр*

хөгжөөгүй учраас шаардлагатай хөрөнгө мөнгө байхгүй бус, нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлж, түүний үр дүнд бий болсон хөрөнгө мөнгийг зохистой ашиглахгүй байгаа учраас хөрөнгө мөнгө байхгүй, ийм учраас эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлөхгүй байгаа гэдгийг ойлголоо. Өөрөөр хэлбэл эдийн засаг хөгжсөн улс үсрэнгүй хөгжих бус, нийгмийн хамгааллын тогтолцоогоо бэхжүүлсэн улс өндөр хөгжилтэй болсныг ойлгож болно. Түүнчлэн хөгжиж буй орнуудад нийгмийн хамгааллын тогтолцоо хангалттай хэмжээнд бэхжээгүй байдаг. Хөгжлийн бэрхшээлийн салбарын хөгжилд нийгмийн хамгааллын тогтолцоо чухал үүрэгтэй. Дээр үед нийгмийн хамгаалал нь эдийн засгийн хөгжилд ачаа болдог гэсэн хандлага зонхилж байсан. Харин Ямашита ахлах зөвлөх нийгмийн хамгаалал нь эдийн засгийн хөгжилтэй холбогдоно гэж тайлбарлаж байлаа. Тийм учраас Монгол Улсын нийгмийн хамгааллын салбар дахь шинэчлэл эдийн засгийн хөгжилд нөлөөлнө гэж байв. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжиж, нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлснээр Монгол Улсын эдийн засаг хөгжиж, ингэснээр бүх хүмүүст ээлтэй нийгэм бий болно гэсэн үг. DPUB төсөл ч гэсэн дээрх ойлголттой санал нэг байгаа бөгөөд энэ утгаараа Ямашита зөвлөхийн лекцийг илүү олон хүмүүст хүргэхийг хүссэн юм. Бидний зорилт ч биеллээ олж, семинарт оролцсон хүмүүс бүгд сэтгэл хангалуун, урам зориг дүүрэн байлаа. Цаашид DPUB төслийн зүгээс энэхүү ойлголтыг илүү олон хүнд хүргэж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахын тулд хичээн ажиллах болно.

### DPUB Холбоо барих хаяг

**Хаяг:** Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

**Фэйсбүүк хуудас:** <https://www.facebook.com/jicadpub>

**Цахим хуудас:** <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

**И-мэйл:** [dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)